ДУНДГОВЬ АЙМАГ
**ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 12 сарын 30 өдөр Дугаар А/136 Хажуу шинэ ус

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16–ний өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан "Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт байршилтай газарт цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар 4800м2 буюу 800м газарт хамгаалалтын зурвасыг хоёр тийш 3м байхаар тооцож газрыг Засаг даргын Тамгын газарт 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчтэй гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Б.Хорол)-д үүрэг болгосугай.

3.Эзэмшсэн газраа зориулалтын дагуу байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлөхийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ө. МӨНХ-АМГАЛАН

482201146

Засаг даргын 2022 оны 12 сарын
30-ны өдрийн А/136 тоот
захирамжийн хавсралт

| № | Нэр | Регистрийн дугаар | Хэмжээ /м.кв/ | Хаяг | Зориулалт | Эзэмшүүлэх хугацаа /жил/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Засаг даргын тамгын газар | 9033572 | 4800м2 | 4-р баг Баяндалайн ард | Эрчим хүчний шугам | 15 |